

Нийслэлийн хэмжээнд Төрийн байгууллагын  
ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг  
хөтлөлтийн Улсын үзлэг зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Архивын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.1, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 150 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 46 дугаар захирамж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 23/15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийг Нийслэлийн хэмжээнд батлагдсан удирдамжийн дагуу 2019 оны 09, 10 дугаар сард зохион байгуулах нийслэлийн салбар комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үзлэгт хамрагдах байгууллагуудын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дүүргийн хэмжээнд салбар комисс байгуулж батлагдсан удирдамж, хуваарийн дагуу үзлэгийг зохион байгуулж ажиллахыг дүүргүүдийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургууль, эрүүл мэндийн байгууллагуудыг улсын үзлэгт хамруулах, удирдамжийн дагуу чанартай зохион байгуулж, дүн, тайланг нэгтгэн, авч хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн саналыг нийслэлийн салбар комисст тайлагнаж ажиллахыг Нийслэлийн Боловсролын газар /Ж.Гантулга/, Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/-т тус тус даалгасугай.

4. Улсын үзлэгт бэлтгэх байгууллагын комиссыг байгууллага бүр дотооддоо байгуулж, үзлэгийн бэлтгэл зохион байгуулалтыг сайтар хангаж дүгнүүлэх, дотооддоо урьдчилсан үзлэг зохион байгуулж, салбар комиссоос үзлэг явуулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг үзлэгт хамрагдах Нийслэлийн нийт байгууллагын дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.

5. Нийслэл, дүүргийн салбар комиссуудын болон үзлэгт хамрагдах байгууллагуудын ажлын бэлтгэл, зохион байгуулалт, явц байдалд хяналт тавьж, тухай бүр холбогдох арга хэмжээг авч, нийслэлийн салбар комисст тайлагнаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж ажиллахыг Нийслэлийн Архивын газар /С.Гаваа/-т үүрэг болгосугай.

6. Улсын үзлэг явуулахад шаардагдах нийт 24,828,000 /хорин дөрвөн сая найман зуун хорин найман мянга/ төгрөгийг Нийслэлийн 2019 оны төсөвт тусгасан Аз жаргалтай хотын индекс тооцож, сайжруулах үе шаттай арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т зөвшөөрсүгэй.

7. Дүүргийн хэмжээнд төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлан, бэлтгэл зохион байгуулалтыг хангаж, шаардагдах төсвийг гаргаж, харьяа байгууллагуудыг бүрэн хамруулж, дүн, тайланг нэгтгэн, авч хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн саналыг хэлэлцсэн хурлын тэмдэглэлийн хамт нийслэлийн салбар комисст тайлагнаж ажиллахыг дүүргийн салбар комиссын дарга нарт үүрэг болгосугай.

8. Улсын үзлэгийн хүрээнд зохион байгуулах нэгдсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хуваарийг баталж, нийслэл, дүүргийн салбар комиссыг сургалт, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах, үзлэгийн нэгдсэн дүн мэдээ болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, амжилттай дүн үзүүлсэн байгууллагын удирдлага, ажилтнуудыг шагнаж урамшуулах, хангалтгүй дүгнэгдсэн байгууллагын удирдлагуудад зохих арга хэмжээг төлөвлөж, үзлэг зохион байгуулах төв комисст, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд тайлагнаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Э.Содномжамц/-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

С.АМАРСАЙХАН

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН УЛСЫН ҮЗЛЭГИЙГ  
УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ НИЙСЛЭЛИЙН  
САЛБАР КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

- Комиссын дарга: -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга
- Комиссын орлогч дарга: -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
- Комиссын гишүүд: -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс;
- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга;
- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Дотоод хяналтын хэлтсийн дарга;
- Нийслэлийн Боловсролын газрын дарга;
- Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга;
- Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга;
- Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга;
- Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга;
- Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга;
- Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга;
- Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга;
- Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга;

-Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга;

-Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга.

Комиссын нарийн  
бичгийн дарга:

-Нийслэлийн Архивын газрын дарга

Нийслэлийн Засаг даргын 2019 оны  
05 дугаар сарын 30-ны өдрийн  
А/518 дугаар захирамжийн хоёрдугаар  
хавсралт

НИЙСЛЭЛИЙН САЛБАР КОМИССООС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН  
АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, АРХИВ, АЛБАН ХЭРЭГ  
ХӨТЛӨЛТИЙН УЛСЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДАХ  
БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ

№	д/д	БАЙГУУЛЛАГЫН НЭР
НЭГ. НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ БАЙГУУЛЛАГА		
1	1	Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
2	2	Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
3	3	Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
4	4	Сүхбаатар дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
5	5	Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
6	6	Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
7	7	Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
8	8	Налайх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
9	9	Багануур дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ХОЁР. ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ		
10	1	Нийслэлийн Архивын газар
11	2	Нийслэлийн Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар
12	3	Нийслэлийн Замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газар
ГУРАВ. УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУД		
13	1	Ахмадын хотхон-1 ОНӨААТҮГ
14	2	Геодези, усны барилга, байгууламжийн газар ОНӨААТҮГ
15	3	Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ
16	4	Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ
17	5	Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ
18	6	Улаанбаатар лифт ОНӨТҮГ
19	7	Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв ОНӨТҮГ
20	8	Хот тохижилтын газар ОНӨААТҮГ
21	9	Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ
ДӨРӨВ. НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВТ, ӨМЧИТ БАЙГУУЛЛАГУУД		
22	1	"Олон улсын худалдаа логистикийн төв" ХК
23	2	"Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төсөл
24	3	Асгат ОНӨААТҮГ
25	4	Багачууд хүнс ОНӨААТҮГ
26	5	Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ
27	6	Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ
28	7	Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ
29	8	Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ
30	9	Монголын хүүхдийн ордон НӨТБ

31	10	Монголын Хүүхдийн урлан бүтээх төв
32	11	Налайхын Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк ОНӨААТҮГ
33	12	Нийгмийн хамгааллын тусгай төв
34	13	Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв ОНӨТҮГ
35	14	Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв
36	15	Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн ОНӨААТҮГ
37	16	Нийслэлийн Нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл-1
38	17	Нийслэлийн Орон сууцны корпораци ХК
39	18	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ
40	19	Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ
41	20	Соёлын төв өргөө
42	21	Улаанбаатар хотын музей
43	22	Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах хоёр дахь төслийг удирдах нэгж
44	23	Улаанбаатар хотын Нийтийн төв номын сан
45	24	Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК
46	25	Улаанбаатар чуулга ОНӨТҮГ
47	26	Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ
48	27	Хүнс хангамж төв ОНӨААТҮГ
49	28	Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор
50	29	Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк ОНӨТҮГ
51	30	Багануур дүүргийн Үйлдвэр, технологийн парк ОНӨТҮГ
<b>ТАВ. НИЙСЛЭЛИЙН ТӨРӨЛЖСӨН ЭМНЭЛГҮҮД</b>		
52	1	Гачуурт тосгоны эрүүл мэндийн төв
53	2	Жаргалант тосгоны эрүүл мэндийн төв
54	3	Наркологийн эмнэлэг
55	4	Нийслэлийн Амгалан амаржих газар
56	5	Нийслэлийн Өргөө амаржих газар
57	6	Нийслэлийн Түргэн тусламжийн төв
58	7	Нийслэлийн Хүрээ амаржих газар
59	8	Туул тосгоны эрүүл мэндийн төв
60	9	Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв
61	10	Хонхор тосгоны эрүүл мэндийн төв
62	11	Шүд, эрүү нүүрний төв
63	12	Энэрэл эмнэлэг
<b>ЗУРГАА. ХУВИЙН ХЭВШЛИЙН БОЛОВСРОЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУД</b>		
64	1	Сургууль-100
65	2	Эрүүл мэндийн байгууллага-150
НИЙТ БАЙГУУЛЛАГА - 313		

## ТӨВ КОМИССЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДАХ БАЙГУУЛЛАГУУД

1. Нийслэлийн ЗДТГ
2. УБ хотын Захирагчийн ажлын алба
3. Нийслэл дэх Төрийн аудитын газар
4. Нийслэлийн ИТХ
5. Нийслэлийн авто замын хөгжлийн газар
6. Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газар
7. Нийслэлийн аялал жуулчлалын газар
8. Нийслэлийн байгаль орчны газар
9. Нийслэлийн боловсролын газар
10. Нийслэлийн газар зохион байгуулалтын алба
11. Нийслэлийн орон сууцны дэд бүтцийн газар
12. Нийслэлийн дотоод аудитын газар
13. Нийслэлийн мал эмнэлгийн газар
14. Нийслэлийн мэдээлэл, технологийн газар
15. Нийслэлийн нийгмийн даатгалын газар
16. Нийслэлийн бүртгэлийн газар
17. Нийслэлийн нийгмийн халамжийн газар
18. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний газар
19. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар
20. Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газар
21. Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар
22. Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар
23. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
24. Нийслэлийн спортын хороо
25. Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар
26. Нийслэлийн онцгой байдлын газар
27. Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газар
28. Нийслэлийн соёл урлагийн газар
29. Нийслэлийн статистикийн газар
30. Нийслэлийн татварын газар
31. Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл, иновацийн газар
32. Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар
33. Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газар
34. Нийслэлийн эрүүл мэндийн газар
35. Нийслэлийн цагдаагийн газар
36. Баянгол дүүргийн ЗДТГ
37. Багануур дүүргийн ЗДТГ
38. Багахангай дүүргийн ЗДТГ
39. Баянзүрх дүүргийн ЗДТГ
40. Налайх дүүргийн ЗДТГ
41. Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ
42. Сүхбаатар дүүргийн ЗДТГ
43. Хан-Уул дүүргийн ЗДТГ
44. Чингэлтэй дүүргийн ЗДТГ
45. Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ
46. Улаанбаатар хотын Ус сувгийн Удирдах газар ОНӨААТҮГ
47. Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК
48. Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК